



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/30

Алтай хот

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Есөнбулаг сумын “Ямбат сайр” нэртэй 393.13 гектар талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатайгаар “Баян боролдой” ХХК-д олгосугай.

2.Хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг биелүүлж ажиллахыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баян боролдой” ХХК (Г. Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3.Хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрөл, зурагзүйн бүртгэлд бүртгэж, хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР